

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр

Тендерийн нэр: “Тусгай зөвшөөрөлтэй талбайн шав тэмдэгүүдийг сэргээн засварлах, акт шинээр гаргах ажил”

Тендер дугаар: МРЦМ/202312119

“Монголросцветмет” ТӨҮГазрын Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байрлах /MV-000174/, Хэнтий аймгийн Дархан суманд байрлах /MV-016657/, Дорноговь аймгийн Иххэт суманд байрлах /MV-011722/ тоот тусгай зөвшөөрөлтэй талбайнуудын шав тэмдэгүүдийг сэргээн засварлах, акт шинээр гаргах ажлыг гүйцэтгэх зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан талаарх дараах нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд (татварын дутуу төлөлт өргүй болон өр төлбөргүй байх)
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2020, 2021 онуудын аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ төсөвт өртгийн 100%-иас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: төсөвт өртгийн 100%-иас багагүй байх.
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жилийн (2021, 2022 он) аль нэг жилд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсвэл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох бөгөөд тендерийн нэмэлт мэдээлэл, тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

Тендерт оролцогч мэдүүлгээ **2023 оны 3 дугаар сарын 24-ны өдрийн 10:00 цагаас** өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГАЗАР